

Хууль зүй, дотоод хэргийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2010 оны 03 дугаар сарын 09-ны
өдрийн 11/09 тоот тушаалын
1 дүгээр хэвсрэлт



БИЧИЛ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар санхүүжиж буй Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхэд олон нийтийн оролцоо, хандлагыг сайжруулах, хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр санаачилсан бичил тэтгэлэг олгох төслийг /цаашид "Төсөл" гэх/ сонгон шалгаруулах, санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төсөл боловсруулах, сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд дор дурдсан үндсэн зарчмыг баримтална:

- 1.2.1. Төслийн зорилт, зорилгод нийцсэн байх;
- 1.2.2. Үр ашигтай байх;
- 1.2.3. Өрсөлдөх тэгш боломжтой байх;
- 1.2.4. Ил тод байх;
- 1.2.5. Судалгаа, нотолгоонд суурилсан, бодит өөрчлөлт, үр дүнг харьцуулах боломжтой байх;
- 1.2.6. Тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурласан байх;

1.3. Дараах баг болон байгууллага төсөл дэвшүүлнэ:

- 1.3.1. Нэг цэгийн үйлчилгээний төв;
- 1.3.2. Түр хамгаалах байр;
- 1.3.3. Хамтарсан баг.

1.4. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь 2 үе шаттай байна:

- 1.4.1. 1 дүгээр шат: Тухайн орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тогтоолоор байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулна;
- 1.4.2. 2 дугаар шат: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулна;

Хоёр. Төсөл бичих чиглэл

2.1. Дор дурдсан чиглэлээр төсөл сонгон шалгаруулж, санхүүжилт олгоно:

2.1.1. Жендэрт суурилсан хүчирхийлэл тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх чиглэлээр орон нутгийн иргэд, эцэг эх, хүүхэд залуучуудыг татан оролцуулах;

2.1.2. Хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах;

2.1.3. Хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны нөхцөл байдал, хүүхэд, эмэгтэйчүүдэд ээлтэй, аюулгүй орчныг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

Гурав. Төсөлд тавигдах шаардлага

- 3.1. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн зорилгод нийцсэн төсөл боловсруулж хүргүүлэх; Төслийн үр шимийг хүртэгч зорилтот хүн амыг тэгш хамруулан, нөөц бололцоог үр ашигтай зарцуулах байдлаар тусгах;
- 3.2. Хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны үйл ажиллагаа, үйлчилгээ болон хуулиар хүлээсэн чиг үүргийн талаар олон нийтэд таниулан мэдүүлэх сургалт сурталчилгааны үйл ажиллагааг тусгах;
- 3.3. Хамтарсан баг болон олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр санал тусгах;
- 3.4. Нийгмийн эмзэг бүлгийн, хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй нөхцөлд буй гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдэд хүрч үйлчлэх зорилгоор олон нийтийг хамарсан үйл ажиллагааг шинэлэг, оновчтой байдлаар зохион байгуулах санал тусгах;
- 3.5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлд буй хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог дэмжих замаар хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах саналыг тусгах;
- 3.6. Бичил тэтгэлэг олгох төслийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журмын 7 дугаар хэсэгт заасан төслийн хэрэгжилтийн үр дүнг тайлагнах, хяналт тавих журмын дагуу саналыг боловсруулах;
- 3.7. Саналыг орон нутгийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэгч, иргэний нийгмийн, төрийн бус байгууллагыг хамруулан, зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулах;
- 3.8. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 18 сараас хэтрэхгүй байна;
- 3.9. Гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар, хор уршгийн талаар эрэгтэйчүүд, өсвөр насны охид, хөвгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгааг орон нутгийн иргэд болон сургуулийн оролцоог дэмжих байдлаар ирүүлсэн санал давуу тал болно;
- 3.10. Хамтарсан багийн санал нь тухайн орон нутгийн олон нийтэд түшиглэсэн орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр ажил, арга хэмжээг тусгасан бол давуу тал болно;

3.11. Хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн санал нь хүүхэд, эмэгтэйчүүдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээг тусгасан бол давуу тал болно.

Дөрөв. Төсөл зарлах, хүлээн авах

4.1. Төсөл сонгон шалгаруулах тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сониноор дамжуулан нийтэд 60 өдрийн хугацаатай зарлана.

4.2. Төслийн баг нь журмын 3-т заасан шаардлага хангасан төсөл боловсруулж, сонгон шалгаруулалтад нэг төсөл ирүүлж, оролцоно. Хугацаа хоцорч ирүүлсэн төслийг хүлээн авахгүй.

4.3. Төслийг тухайн орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албанд заасан хугацаанд хүргүүлнэ.

4.4. Орон нутгийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг нь төсөл хүлээн авсан бүртгэлийн хуудсыг хүлээн авах хугацаа дууссанаас хойш 24 цагийн дотор төсөл хэрэгжүүлэх нэгжийн gender.g9198@gmail.com цахим хаягт илгээнэ. Төслийн бүртгэлийн жагсаалтад бүртгээгүй төслийг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

Тав. Төсөл сонгон шалгаруулах, гэрээ байгуулах

5.1. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт:

5.1.1. Энэхүү журмын 4.4-т заасан цахим хаягт ирүүлсэн төслүүдийг нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад өрсөлдүүлэх бөгөөд нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг тухайн орон нутгаас томилогдсон ажлын хэсэг зохион байгуулна.

5.1.2. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг төслийн материал хүлээн авсан хугацаанаас хойш хуанлийн 21 өдөрт багтаан зохион байгуулна.

5.1.3. Орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг доод тал нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд энэ журмын Хавсралт 1-д заасан байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Ажлын хэсгийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй байна.

5.1.4. Ажлын хэсэг энэ журмын 5.1.5-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулна.

5.1.5. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад төслийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хувийн жин %
----------	-------------------------	------------------------------------	---------------------

1	Төслийн үндэслэл	Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитой байх, дэвшүүлж байгаа шинэ санаачилга, шийдлийн ач холбогдол тодорхой байх;	25%
2	Гарах үр дүн	Тодорхойлсон асуудлаа оновчтой шийдвэрлэж, үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц байх;	25%
3	Төлөвлөгөө, төсөв	Санхүүгийн төлөвлөгөө, төсөв нь үндэслэл сайтай, бодитой байх	15%
4	Хэрэгжих боломж	Зорилго, зорилт, үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө нь хоорондоо уялдаа холбоо сайтай, бодитой байх;	25%
5	Тогтвортой байдал	Төслийн үйл ажиллагаа цаашид төсөл дууссаны дараа хэвшил болж үргэлжлэх боломжтой байх.	10%

5.1.6. Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн онооны нийлбэрийн дундаж нь 80-100 хувь хүртэл оноо авсан төслийг нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцно.

5.1.7. Нэгдүгээр шатанд шалгарсан төслүүдийн материалыг дараах баримт бичгийн хамт битүүмжлэн *Хууль зүй, дотоод хэргийн яам, Худалдааны гудамж 6/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Утас 77449198, "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл хэрэгжүүлэх нэгж, 606 тоотод* сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

5.1.7.1 Орон нутгийн харьяа байгууллагын албан бичиг;

5.1.7.2 Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, шийдвэр, санал;

5.1.7.3 Шалгарсан төслийн материал /эх хувиар/.

5.2. Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт:

5.2.1. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн төслийг хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад оруулна. Сонгон шалгаруулалтад тухайн орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн гаралтын тоо, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хүртээмж, хүн амын нягтаршил, санхүүжилт зэрэг хүчин зүйлийг харгалзан үзнэ. Энэ журмын 2, 3 дугаар хэсэгт заасан шаардлага, хүрээ, чиглэлд нийцсэн төслийг шалгаруулж бичил тэтгэлгийг олгоно.

5.2.2. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтаас шалгарсан төслүүдийг үнэлэх *Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар* байгуулсан ажлын хэсэг нийт 30 төслийг шалгаруулна.

5.2.3. Төслийн зорилтот орон нутаг болох Увс, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүргийн хамтарсан багт тус бүр нэг /нийт 5/, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бусад хамтарсан багийн дунд 20,

нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны дунд 5, нийт 30 төсөлд тэтгэлэг олгоно.

5.2.4. Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад төслийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хувийн жин %
1	Төслийн үндэслэл	Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитой байх, дэвшүүлж байгаа шинэ санаачилга, шийдлийн ач холбогдол тодорхой байх;	30%
2	Гарах үр дүн	Тодорхойлсон асуудлаа оновчтой шийдвэрлэж, үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц байх;	40%
3	Хэрэгжих боломж	Зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө нь бодитой, хэрэгжих боломжтой байх	30%

5.2.5. Ажлын хэсгийн нийт гишүүдийн үнэлгээгээр өндөр оноо авсан эхний 30 төслийг хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцон, ажлын хэсэг шийдвэр гаргана;

5.2.6. Ажлын хэсгийн үнэлгээ, дүгнэлтэд дарга, бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна;

5.2.7. Сонгон шалгаруулалтын шийдвэрийг Азийн хөгжлийн банканд илгээн гэрээ байгуулах зөвшөөрөл авна;

5.2.8. Шалгарсан 30 төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах зөвшөөрөл Азийн хөгжлийн банкнаас ирснээс хойш ажлын 5 өдрийн дотор төсөл хэрэгжүүлэгчид Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шалгарсан мэдэгдлийг албан бичгээр хүргүүлнэ.

5.2.9. Шалгарсан төслийн гэрээ байгуулах мэдэгдлийг төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлснээс хойш 14 өдөрт багтаан “Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх” тухай гэрээ байгуулна.

Зургаа. Төслийн санхүүжилт

6.1 Нэг төслийн санхүүжилтийн хэмжээ 5000 ам. доллар хүртэл байна. Гэрээний санхүүжилтийн валютыг гэрээ байгуулах өдрийн Монгол банкны албан ханшаар хөрвүүлж төгрөгөөр байгуулна

6.2 Гэрээнд төслийн санхүүжилтийг дараах хуваариар олгохоор тусгана:

6.2.1. Төсөл тус бүрийн санхүүжилтийн урьдчилгаа 2000 ам.долларт тэнцэх төгрөг байна.

6.2.2. Урьдчилгаа санхүүжилтийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 21 өдөрт багтаан олгоно.

6.2.3. Төслийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 21 өдөрт багтаан дараагийн санхүүжилтийг олгоно.

Долоо. Төслийн хэрэгжилтийн үр дүнг тайлагнах, хяналт тавих

7.1. Төслийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Азийн хөгжлийн банк, хэрэгжүүлэгч байгууллагууд, Төсөл хэрэгжүүлэх нэгж хамтран үйл ажиллагаатай танилцан явцын хяналт, үнэлгээ хийнэ.

7.2. Төслийг хэрэгжүүлэгч болон хариуцагч байгууллага төслийн гүйцэтгэлийн 60 хувь хэрэгжсэний дараа хэрэгжилтийн явцын /үйл ажиллагааны болон санхүүгийн/ тайланг Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ.

7.3. Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тайлан, мэдээг цаг тухайд нь хүргүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс тогтмол хяналт тавин ажиллана.

7.4. Тухайн орон нутгийн харьяа байгууллага төслийн хэрэгжилтийн үр дүнгийн тайланг хэлэлцэн дүгнэлт гаргана. Төслийн тайлан, дүгнэлтийн хамтаар гэрээнд заасан хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ.

7.5. Төслийн тайлан болон төслийн үр дүнгийн биелэлтээр бий болсон ажлын танилцуулга, ухуулга сурталчилгаа хийсэн, шинэ санаа нэвтрүүлсэн тухай үйл ажиллагааг тухайн орон нутгийн харьяа байгууллага болон төсөл хэрэгжүүлэх нэгж, Азийн хөгжлийн банк, Хууль зүй, дотоод хэргийн яам, хэрэгжүүлэгч байгууллагын дунд уулзалт танилцуулга зохион байгуулна.

7.6. Төсөл хэрэгжүүлэгчийн буруугаас төслийн явцын үнэлгээ хангалтгүй гарсан тохиолдолд зөрчлийг арилгуулах талаар орон нутгийн харьяа байгууллагад төсөл хэрэгжүүлэх нэгжээс шаардлага хүргүүлэх ба зөрчлийг арилгасан талаарх тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ. Зөрчлийг арилгахтай холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч тал хариуцна.

Найм. Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

8.1. Төслийн хүлээгдэж буй үр дүнгээс хамаарч шалгуур үзүүлэлт ялгаатай байна. Шалгуур үзүүлэлт нь төслийн гүйцэтгэл, ач холбогдол, үр ашгийг үнэлэх хэмжүүр болно.

8.2. Тухайн төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг “Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх” гэрээнд тодорхой тусгасан байна.

8.3. Гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн төслийн эцсийн үр дүнг үнэлнэ.

Ес. Маргаан шийдвэрлэх

9.1. Маргаан шийдвэрлэх зарчмыг гэрээнд тодорхой тусгана.

Арав. Бусад зүйл

10.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах загвар, маягтууд нь дараах бүрдэлтэй байна:

- Хавсралт 1 Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн
- Хавсралт 2 Төслийн мэдүүлгийн маягт
- Хавсралт 3 Төслийн багийн танилцуулга
- Хавсралт 4 Төслийн үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөө
- Хавсралт 5 Бүртгэлийн хуудас
- Хавсралт 6 Нэгдүгээр шатны үнэлгээний хуудас
- Хавсралт 7 Нэгдүгээр шатны үнэлгээний нэгтгэлийн хуудас
- Хавсралт 8 Нэгдүгээр шатнаас шалгарсан төслийн мэдээлэл
- Хавсралт 9 Хоёрдугаар шатны үнэлгээний хуудас
- Хавсралт 10 Хоёрдугаар шатны үнэлгээний нэгтгэлийн хуудас
- Хавсралт 11 Төслийн явцын тайлангийн маягт
- Хавсралт 12 Төслийн эцсийн тайлангийн маягт
- Хавсралт 13 Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний загвар

---o0o---

БИЧИЛ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ТӨСЛИЙН НЭГДҮГЭЭР ШАТНЫ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Аймаг/дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга
Гишүүд:	Аймаг/дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Аймаг/дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Аймаг/дүүргийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн газрын мэргэжилтэн
	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
	Аймаг/дүүргийн Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Аймаг/дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн мэргэжилтэн
	(Төслийн зорилтот орон нутагт Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн Орон нутгийн зохицуулагчийг томилж болно)

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
2 дугаар хавсралт

ТӨСЛИЙН МЭДҮҮЛГИЙН МАЯГТ

А. ТӨСЛИЙН НЭР БОЛОН ЧИГЛЭЛ	
1.	Төслийн нэр:
2.	Төслийн багийн ажиллаж байгаа чиглэл (тохирох чиглэлээ (√) тэмдэглэнэ): <input type="checkbox"/> Нэг цэгийн үйлчилгээний төв; <input type="checkbox"/> Түр хамгаалах байр; <input type="checkbox"/> Хамтарсан баг;
3.	Төслийн багийн харьяалах байгууллага чиглэл:
4.	Төслийн чиглэл (Тохирох чиглэлээ (√) тэмдэглэнэ. Тодорхойлолтыг ХЗДХЯ-ны журмаас харна уу.): <input type="checkbox"/> Нэг цэгийн үйлчилгээний төв <input type="checkbox"/> Түр хамгаалах байр; <input type="checkbox"/> Хамтарсан баг;
5.	Санхүүжилтийн нийт дүн
6.	Хэрэгжих хугацаа (нийт хугацаа 18 сараас хэтрэхгүй байна)
7.	Төсөл хэрэгжүүлэгч баг: Төсөл хэрэгжүүлэгч ахлагчаа сонгоно. Багийн ахлагч: Овог нэр:..... Хүйс: Утас:..... И- мэйл хаяг:..... Регистрийн дугаар:..... Багийн гишүүд: Овог, нэр..... Хүйс:..... Регистрийн дугаар:.....
Б. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	
8.	Төслийн үндэслэл: Энэ төсөлтэй холбоотой өнөөгийн байдал, тухайн төслийг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл, суурь нөхцөл байдлын талаарх мэдээллийг бичнэ. Өнөөгийн нөхцөл байдлыг харуулах зураг, баримт, судалгаа зэргийг хавсаргаж болно.

9.	Төслийн гол зорилго: Энэ төслийг хэрэгжүүлэх үндсэн зорилго, зорилт, гарах өөрчлөлтийн талаар тусгана.	
10.	Төслөөс гарах үр дүн: Төсөл хэрэгжүүлснээр хүрэх үр дүнгийн төсөөлөл, тухайн үр дүн нь өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн сайжруулах талаар бичнэ. Үр дүнг тодорхой, хэмжигдэхүйц, бодитой, тухайн хугацаандаа хэрэгжихүйц байхаар бичнэ.	
11.	Үр шим хүртэгчид: Төслийн зорилтот бүлгийг тодорхойлж, тэдний төслөөс ямар үр шим хүртэх талаар тусгана.	
	Үр шим хүртэгчид (Зорилтот бүлэг, нийт хүний тоо)	Төслөөс хүртэх үр шим (Үр шим хүртэгчдийн оролцоо, гарах үр дүн)
12.	Төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх боломж: Тухайн төслөөс гарах үр дүнг хэрхэн нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх боломжтой талаар тусгана.	

Жич: Хуудасны тоог 5-с дээш хэтрүүлэхгүй байх.

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
3 дугаар хавсралт

ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГЫН МАЯГТ

1. Багийн гишүүний үүрэг хариуцлага: Багийн гишүүний нэр, гүйцэтгэх ажил, чиг үүргийн талаар тусгана.		
№	Овог, нэр	Гүйцэтгэх ажил, үүрэг
1.		
2.		
3.		
4.		
5.		
2. Эрсдэл, шийдвэрлэх арга зам: Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн багасгах боломжтой талаар дурдана.		
3. Төслийн тогтвортой байдал, үр нөлөө: Төсөл хэрэгжиж дууссаны дараа тухайн төслийн тогтвортой байдлыг хэрхэн хангах, нэвтрүүлсэн үйл ажиллагааг хэрхэн хэвшил болгон үргэлжлүүлэх талаар бичнэ.		

Жич: Хуудасны тоог 3-с дээш хэтрүүлэхгүй байх.

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
4 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ, САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ МАЯГТ

1. Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: Төлөвлөж буй үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх, дуусах хугацаа (Он, сар)	Гарах үр дүн	Шаардлагатай санхүүжилтийн дүн (төгрөгөөр)
ЭХНИЙ ҮЕ ШАТ			
Үйл ажиллагаа 1:			
ХОЁР ДАХЬ ҮЕ ШАТ			
Үйл ажиллагаа 1:			

**НЭГДҮГЭЭР ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр:.....

2.	Төслийн нэр:	
3.	Төслийн багийн ахлагч:	Овог нэр:..... Хүйс:.....
4.	Төслийн багийн гишүүний тоо: (төслийн удирдагчаас бусад)	Нэг. Нийт Үүнээс: Эрэгтэй..... Эмэгтэй.....
5.	Төслийн үргэлжлэх хугацаа (сараар):	Төсөл эхлэх он, сар, өдөр: Төсөл дуусах он, сар, өдөр:
6.	Төсөв (ам.доллороор):	
7.	Төслийн чиглэл	(Тохирох чиглэлээ (✓) тэмдэглэнэ. ХЗДХЯ-ны журмаас тодорхойлолтыг харна уу.): <input type="checkbox"/> Нэг цэгийн үйлчилгээний төв; <input type="checkbox"/> Түр хамгаалах байр; <input type="checkbox"/> Хамтарсан баг;

8. Төслийн үнэлгээг ашиг сонирхлын зөрчилгүй хийсэн гэдгээ баталж байна.

**(Хэрвээ тухайн төсөлд ямар нэг ашиг сонирхлын зөрчил байгаа бол үнэлгээ хийхгүй бөгөөд тайлбараа*

"Тэмдэглэл" хэсэгт бичихийг анхаарна уу.

№	Шалгуур үзүүлэлтүүд ¹	Тайлбар	Үнэлгээ				
			1	2	3	4	5
1.	Төслийн үндэслэл	Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитой байх, дэвшүүлж байгаа шинэ санаачилга, шийдлийн ач холбогдол тодорхой байх (25%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Гарах үр дүн	Тодорхойлсон асуудлаа оновчтой шийдвэрлэж, үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц байх (25%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	Төсөв	Санхүүгийн төлөвлөгөө, төсөв нь үндэслэл сайтай, бодитой байх (15%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4.	Хэрэгжих боломж	Зорилго, зорилт, үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө нь хоорондоо уялдаа холбоо сайтай байх (25%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5.	Тогтвортой байдал	Төслийн үйл ажиллагаа цаашид төсөл дууссаны дараа хэвшил болж үргэлжлэх боломжтой байх (10%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Нийт оноо							

Баталгаажуулалт

Гишүүний овог, нэр:
үсэг:.....

Гарын

Тэмдэглэл:

¹Бичил төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам” (201... оны ... дүгээр сарын ...-ний өдрийн тушаал)

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
7 дугаар хавсралт

**НЭГДҮГЭЭР ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
ДҮНГИЙН НЭГТГЭЛИЙН ХУУДАС**

Аймаг/дүүргийн харьяа байгууллагын нэр:

Нэгтгэл хийхдээ төслийн чиглэлийг дараах байдлаар тэмдэглэнэ үү:

- T.1 Нэг цэгийн үйлчилгээний төвүүд;
- T.2 Түр хамгаалах байрууд;
- T.3 Хамтарсан багууд;

№	Төслийн нэр	Төслийн чиглэл	Багийн ахлагчийн нэр	Ажлын хэсгийн гишүүний оноо							Дундаж оноо	Эзэлсэн байр
				Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7		

Баталгаажуулалт

Нэгтгэл хийсэн шүүгчдийн багийн нарийн бичгийн даргын овог нэр:.....Гарын үсэг:..... Он, сар, өдөр:.....

Хянасан: Шүүгчдийн багийн ахлагчийн овог нэр:..... Гарын үсэг:..... Он, сар, өдөр:.....

Шалгарсан төслийн мэдээлэл

№	Төслийн нэр	Багийн ахлагч нэр	Төслийн багийн ажиллаж буй чиглэл	Төслийн төрөл ¹	Төсөл хэрэгжих хугацаа	Төслийн зорилго	Гарах үр дүн	Дунда ж оноо	Эзэлсэн байр
1.									
2.									
3.									
4.									
5.									
6.									

Гишүүдийн гарын үсэг:

- | | |
|-------------------|------------------|
| 1. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 2. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 3. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 4. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 5. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 6. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |
| 7. Овог нэр:..... | Гарын үсэг:..... |

¹ Төслийн төрлийн тэмдэглэгээ:

Т.1 Нэг иэлийн үйлчилгээний төв;

Т.2 Түр хамгаалах байр;

Т.3 Хамтарсан баг;

**ХОЁРДУГААР ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Төслийн чиглэл (Тохирох чиглэлээ (✓) тэмдэглэнэ. Тодорхойлолтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас харна уу.):

- Нэг цэгийн үйлчилгээний төв;
- Түр хамгаалах байр;
- Хамтарсан баг;

Төслийн нэр

№	Шалгуур үзүүлэлтүүд ¹	Тайлбар	Үнэлгээ				
			1	2	3	4	5
1.	Төслийн үндэслэл	Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитой байх, дэвшүүлж байгаа шинэ санаачилга, шийдлийн ач холбогдлыг тодорхой гаргасан байх (30%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Гарах үр дүн	Тодорхойлсон асуудлаа оновчтой шийдвэрлэж, үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц байх (40%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	Хэрэгжих боломж	Зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө нь бодитой, хэрэгжих боломжтой байх (30%);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Нийт оноо							

Төслийн үнэлгээг ашиг сонирхлын зөрчилгүй хийсэн гэдгээ баталж байна.

Ажлын хэсгийн гишүүний нэр: **Гарын үсэг:**.....

Баталгаажуулалт

Үнэлгээний хуудас авсан:

Хянасан:

Туслах ажилтны нэр:

Нарийн бичгийн даргын нэр:.....

Гарын үсэг

Гарын үсэг

Тэмдэглэл:

¹Бичил төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам” (201... оны ... дүгээр сарын ...-ний өдрийн тушаал)

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
10 дугаар хавсралт

**ХОЁРДУГААР ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
ДҮНГИЙН НЭГТГЭЛИЙН ХУУДАС**

Орон нутгийн харьяа байгууллагын нэр:

Нэгтгэл хийхдээ төслийн чиглэлийг дараах байдлаар тэмдэглэнэ үү:

T.1 Нэг цэгийн үйлчилгээний төвүүд;

T.2 Түр хамгаалах байрууд;

T.3 Хамтарсан багууд ;

№	Төслийн нэр	Төслийн чиглэл	Багийн ахлагчийн нэр	Ажлын хэсгийн гишүүдийн оноо							Дунда ж оноо	Эзэлсэн байр
				Гишүүн н 1	Гишүүн н 2	Гишүүн н 3	Гишүүн н 4	Гишүүн н 5	Гишүүн н 6	Гишүүн 7		

Баталгаажуулалт

Нэгтгэл хийсэн шүүгчдийн багийн нарийн бичгийн даргын овог нэр:..... Гарын үсэг:..... Он, сар, өдөр:.....

Хянасан: Шүүгчдийн багийн ахлагчийн овог нэр:..... Гарын үсэг:..... Он, сар, өдөр:.....

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЙЛАН

А. ТӨСЛИЙН НЭР БОЛОН ЧИГЛЭЛ	
1.	Төслийн нэр:
2.	Төслийн багийн ахлагчийн нэр:
3.	Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүдийн тоо:..... Үүнээс: эрэгтэй:..... эмэгтэй:..... Багт өөрчлөлт орсон эсэх: <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм Хэрэв тийм бол төслийн багаас гарсан гишүүний нэр болон шалтгааныг дараах байдлаар жагсааж бичнэ: 1. Гарсан гишүүний нэр..... Хүйс..... Гарсан шалтгаан..... 2. Шинээр нэмэгдсэн гишүүний нэр..... Утас болон и-мэйл хаяг.....
4.	Төслийн чиглэл (Тохирох чиглэлээ (√) тэмдэглэнэ.) <input type="checkbox"/> Нэг цэгийн үйлчилгээний төв; <input type="checkbox"/> Түр хамгаалах байр; <input type="checkbox"/> Хамтарсан баг;
5.	Төслийн санхүүжилтийн нийт дүн (ам.доллороор):
6.	Төсөл хэрэгжих нийт хугацаа (сараар):
Б. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	
7.	Төслийн гол зорилго:
8.	Төсөл хэрэгжүүлэх шатанд гарсан үр дүн (Товч жагсааж бичнэ. Дэлгэрэнгүйг дараах хуудаст үйл ажиллагаа тус бүрээр гаргахыг анхаарна уу): 1. 2. 3.

9. Төслийн эхний шатанд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт болон гарсан үр дүн:

Гүйцэтгэсэн үйл ажиллагаа	Эхэлсэн, дууссан хугацаа (Он, сар)	Үр шимийг хүртэгч бүлэг (Төслийн зорилтот бүлэг; нийт хүний тоо; эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоо)	Бодит үр дүн болон өөрчлөлт
Үйл ажиллагаа 1:			
Үйл ажиллагаа 2:			
Үйл ажиллагаа 3:			

10. Төсөл хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэл, сургамж, шийдвэрлэсэн байдал (төлөвлөсөн боловч хийгдээгүй үйл ажиллагаа эсвэл төлөвлөөгүй боловч авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа гэх мэт):

11. Төслийн сайн туршлага, сургамж:

*Санхүүжилтийн дэлгэрэнгүй тайланг БТ 9198-МОН Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн албанд тайлагнана.

ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

А. ТӨСЛИЙН НЭР БОЛОН ЧИГЛЭЛ	
1.	Төслийн нэр:
2.	Төслийн багийн ахлагчийн нэр:
3.	Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүдийн тоо:..... Үүнээс: эрэгтэй:..... эмэгтэй:..... Багт өөрчлөлт орсон эсэх: <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм Хэрэв тийм бол төслийн багаас гарсан гишүүний нэр болон шалтгааныг дараах байдлаар жагсааж бичнэ: 1. Гарсан гишүүний нэр..... Хүйс..... Гарсан шалтгаан..... 2. Шинээр нэмэгдсэн гишүүний нэр..... Утас болон и-мэйл хаяг.....
4.	Төслийн чиглэл (Тохирох чиглэлээ (√) тэмдэглэнэ.) <input type="checkbox"/> Нэг цэгийн үйлчилгээний төв; <input type="checkbox"/> Түр хамгаалах байр; <input type="checkbox"/> Хамтарсан баг;
5.	Төслийн санхүүжилтийн нийт дүн (ам.доллороор):
6.	Төсөл хэрэгжих нийт хугацаа (сараар):
Б. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	
7.	Төслийн гол зорилго:
8.	Төсөл хэрэгжүүлэх шатанд гарсан үр дүн (Товч жагсааж бичнэ. Дэлгэрэнгүйг дараах хуудаст үйл ажиллагаа тус бүрээр гаргахыг анхаарна уу): 1. 2. 3.

9. Төслийн хэрэгжилт, үр дүн: Төслийн үйл ажиллагаа, зорилтот бүлэг болон гарсан үр дүнгээс хамаарч хүснэгтийг өөрчилж болно.

№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Эхэлсэн, дууссан хугацаа (Он, сар)	Төслийн зорилтот бүлэг, тэдний хүртсэн гол үр шим	Үр дүн болон бодит өөрчлөлт	
				Төслийн эхэн дэх суурь үзүүлэлт	Төслийн эцэст гарсан үзүүлэлт
1.					
2.					
3.					
4.					
5.					
6.					
7.					

10. Төслийн тогтвортой байдал, үр нөлөө:

11. Төслийг түгээн дэлгэрүүлэх боломж:

12. Төсөл хэрэгжүүлсэн сайн туршлага, сургамж:

Бичил тэтгэлэг олгох
төсөл сонгон шалгаруулах
санхүүжүүлэх журмын
13 дугаар хавсралт

БАТЛАВ.

ХЗДХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.БИЛГҮҮН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20.... он... сар... өдөр

№

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээг нэг талаас Хууль зүй, дотоод хэргийн яамыг төлөөлж /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас төслийн багийг төлөөлж ахлагчовогтой /РД...../ /цаашид "Төсөл хэрэгжүүлэгч" гэх Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны оны дугаар тушаалаар батлагдсан "Бичил тэтгэлэг олгох төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх" журмыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 2.1. Энэхүү гэрээ нь Азийн Хөгжлийн Банк, Ядуурлыг Бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй 9198-МОН " Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл" (ХЭЭГБХТТ) -ийн хүрээнд сэдэвтэй төсөл /цаашид "төсөл" гэх/ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа болон түүнд оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Захиалагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
- 3.1.1. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн баталгаажуулалтын талаар тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар шаардлага хүргүүлэх ба тайлбар гаргуулж авах;
 - 3.1.2. Төслийг хугацаанд нь хийж гүйцэтгэхийг шаардах;
 - 3.1.3. Гэрээнд заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч талд санхүүжилтийг олгох;
 - 3.1.4. Төслийн үр дүнг хүлээн авч, үнэлж баталгаажуулах

ДӨРӨВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1. Төсөл хэрэгжүүлэгч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 4.1.1. Төслийг хэрэгжүүлэхэд захиалагч талаас зөвлөгөө, дэмжлэг авах;
 - 4.1.2. Төслийг хугацаандаа багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг гэрээний Хавсралт 1-т заасны дагуу чанартай хийж гүйцэтгэх;
 - 4.1.3. Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу гэрээний Хавсралт 2-т заасны дагуу үр ашигтай зарцуулах;
 - 4.1.4. Төсөл хэрэгжүүлэгч нь дотоод зохион байгуулалт, Хууль зүй, дотоод хэргийн яамны " оны дугаар тушаалаар батлагдсан "Бичил тэтгэлэг олгох төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх" журмыг баримтлан төслийг хэрэгжүүлэх;
 - 4.1.5. Төслийн санхүүжилтийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөхийг Захиалагчаас шаардах;
 - 4.1.6. Төсөл хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй үндсэн хөрөнгийг¹ худалдан авах тохиолдолд Азийн Хөгжлийн Банкны (цаашид АХБ гэх) худалдан авах ажиллагааны бодлого, горимд нийцүүлж Хавсралт 3-ийг ашиглах;
 - 4.1.7. ХЭЭГБХТ төслийн санхүүжилтээр бий болсон үндсэн хөрөнгө /багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютер, тавилга гэх мэт/-ийг тухай бүр харьяалах дээд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгүүлэх.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 5.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2. Гэрээний хугацаа нь энэхүү гэрээнд заасан төсөл хэрэгжүүлэх хугацаанд буюу оны дүгээр сарын -ны өдрөөс оны сарын-ны өдрийг хүртэл нийт сар байна.

ДОЛОО. САНХҮҮЖИЛТ

- 7.1. Захиалагч тал энэхүү төслийн эхний санхүүжилт болох 2,000 ам доллар буюу түүнтэй тэмцэх хэмжээний төгрөгийг (гэрээ хийгдсэн өдрийн Монгол банкны албан ханшийг ашиглах) /.....үсгээр...../ төгрөгийг гэрээ байгуулснаас хойш 21 хоногийн дотор, төслийн явцын тайланг Захиалагчид хүлээлгэн өгч, төслийн явцад мониторингийн ажлын хэсэг хангалттай үнэлгээ өгснөөс хойш 21 хоногийн дотор, үлдэгдэл санхүүжилт болох/үсгээр./ төгрөгийг байгууллагын дансаар дамжуулан банкны тоот дансаар Төсөл хэрэгжүүлэгч талд шилжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч төслийн үйл ажиллагаа болон санхүүжилтийн тайланг Хавсралт 5-д заасан маягтаар гаргана.
- 7.2. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү гэрээний 7.1-д заасан үе шат бүрийн санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн үе шатны төгсгөлд ХЭЭГБХТ Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүд тайлагнана.
- 7.3. Төсөл хэрэгжүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн яам -ны " оны дугаар тушаалаар батлагдсан "Бичил тэтгэлэг олгох төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх" журмын 7.5 дугаар заалтын дагуу тухайн төслийг дуусган гүйцэтгүүлэх эсвэл боломжгүй нөхцөлд Захиалагч талд санхүүжилтийг эргэн төлүүлнэ.
- 7.4. Төсөл хэрэгжүүлэгч нь Үндсэн хөрөнгөнд хуучин бараа авах, өөр ажлын гүйцэтгэлийг төслийн ажилд тооцох зэрэг Захиалагчийн итгэлийг алдсан гэж буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь баримтаар тогтоогдвол Захиалагч талд санхүүжилтийг эргэн төлүүлнэ.

¹ Үндсэн хөрөнгө гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал тухайн байгууллагад бүртгэлтэй үлдэж ашиглагдах, худалдах зориулалтгүй биет хөрөнгө болно.

НАЙМ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 8.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй мөн энэхүү гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээг аль нэг талын санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцална.
- 8.2. Энэхүү гэрээнд заасан хугацаанаас гэрээний 8.1-д зааснаас бусад тохиолдолд гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлахыг хориглоно.
- 8.3. Талууд гэрээг цуцлах тухай саналаа нөгөө талдаа ажлын 10 өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд талуудын хооронд маргаан үүсвэл талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд хэрвээ тохиролцоонд үл хүрвэл хуулийн дагуу харьяаллын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- 10.1. Гэрээнд Төсөл хэрэгжүүлэгчийн төслийн мэдүүлгийг Хавсралт 4 болгоно. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 10.2. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.
- 10.3. Гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй 3 хувь үйлдэв.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч:

Төсөл хэрэгжүүлэгч:

Хууль зүй, дотоод хэргийн яамны
Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны
газрын дарга / Төслийн захирал

Төслийн багийн ахлагч

.....

.....

Т. Бат-Өлзий

/овог, нэр/

.....

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн
хүчирхийлэлтэй тэмцэх төслийн зохицуулагч

Утас:

.....

Хаяг:

И-мэйл хаяг: coordinator.g9198@gmail.com

РД:

И-мэйл хаяг:

Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх
..... оны дугаар сарын -ны өдрийн
..... дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

1. Төслийн нэр:.....
2. Харьяа газар, байгууллагын нэр:.....
3. Төслийн зорилго:.....
.....
.....
4. Төсөл хэрэгжих хугацаа: Эхлэх.....(он, сар өдөр)..... Дуусах... (он, сар өдөр).....
5. Үр дүнгийн даалгавар:

Гарах үр дүн:	Үйл ажиллагаа	Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд		
		Хэмжих нэгж	Төслийн эхэн дэх суурь үзүүлэлт	Төслийн эцэст гарах үзүүлэлт
1.	1.1	(Жишээ: % эсвэл тоон үзүүлэлт)		
	1.2			
2.	2.1			
	2.2			
3.	3.1			
	3.2			

Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх
 20...оны дугаар сарын -ны өдрийн
 дугаар гэрээний 2 дугаар хавсралт

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Төслийн нийт санхүүжилт төгрөг
2. Санхүүжилтийн задаргаа:

Хэрэгжүүлэх шат хугацаа	*Зардлын ангилал ¹	Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Үе шат 1: оны .. сарын... оны... сарын ... хүртэл (Урьдчилгаа санхүүжилт)	Хэрэглээний зардал:					
	*Үндсэн хөрөнгийн зардал ²					
	Үйл ажиллагааны зардал					
Үе шат 2: оны .. сарын... оны... сарын ... хүртэл (Эцсийн санхүүжилт)	Хэрэглээний зардал					
	Үндсэн хөрөнгийн зардал					
	Үйл ажиллагааны зардал					
Нийт дүн						

***Зардлын ангилал¹:**

Хэрэглээний зардал гэдэг нь Төсөл хэрэгжүүлэгч багийн унаа тээвэр, холбоо харилцаа, хоол унд гэх мэт төсөл хэрэгжүүлэх үед шаардлагатай зардлыг хэлнэ. Хэрэглээний зардал нь нийт төсвийн 10% -аас хэтрэхгүй.

**Үндсэн хөрөнгийн зардал²* гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглагдах боломжит хугацаа нь хязгаарлагдмал биет хөрөнгө болох компьютер, канон, принтер, тавилга зэрэг болно. Эдгээр үндсэн хөрөнгийг худалдан авах болон тухайн байгууллагын үндсэн хөрөнгө болж үлдэх эд хөрөнгийг угсарч хийх, тээвэрлэхтэй холбоотой зардлыг хэлнэ.

Үйл ажиллагааны зардал гэдэг нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг хэлнэ.

Жич: Төрийн байгууллагын албан хаагч мөнгөн хэлбэрээр урамшуулал, цалин авах эрхгүй юм. Санхүүгийн баримт бүрдүүлэлтэд холбогдох баримт материалыг тооцохгүй болохыг анхаарна уу.

Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх
20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн
..... дугаар гэрээний 3 дугаар хавсралт

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Төслийн нэр/дугаар: _____
Байгууллагын нэр: _____
Огноо: _____
Оролцогчийн нэр: _____
Оролцогчийн хаяг: _____

1. Доорх нэр төрлийн барааны үнийн саналыг ирүүлэхийг урьж байна.

	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг

2. Энэхүү урилгын дагуу бүх нэр төрлийн бараанд үнийн санал ирүүлнэ. Бүх нэр төрлийн барааны үнийн саналыг харьцуулан үнэлгээ хийж техникийн тодорхойлолтын шаардлага хангасан хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулан сонгон авна.
3. Үнийн санал нь доорх хаягийн дагуу хаяглагдсан байна.

[Захиалагчийн хаяг] _____
Утас: _____
И-мэйл: _____

4. Үнийн саналд тухайн барааны нэр төрөл тус бүрийн техникийн тодорхойлолтыг хангасан каталог, хувилсан материал эсвэл тухайн бараатай холбоотой мэдээлэл, түүнчлэн тухайн бараанд засвар үйлчилгээ үзүүлэх Монгол улс дахь нэгжийн нэр, хаягийг тусгасан байна.
5. Тавдугаар догол мөрд тусгагдсан баримт бичгүүдийг захиалагчийн хаягийн дагуу ... оны ... сарын ... өдөр, ... цаг (хүлээн авах эцсийн огноо, цагийг нөхөж бичнэ)-ны дотор ирүүлнэ.
6. Үнийн саналаа и-мэйлээр ирүүлж болно.
7. **ҮНИЙН САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА:** Үнийн санал нь хүлээн авахаар товлосон хугацаанаас эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
8. Доорх хаягийн дагуу мэдээлэл авч болно.

Захиалагчийн хаяг: _____
Утас: _____
И-мэйл: _____

Хүндэтгэсэн:

Захиалагчийн нэр/гарын үсэг _____

Захиалагчийн хаяг _____

Утас _____
И-мэйл: _____

ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

1. Төслийн нэр/дугаар -----
2. Хэрэгжүүлэгч байгууллага -----
3. Барааны нэр төрөл -----
4. Төсөвт өртөг /төгрөг/ -----
5. Уригдсан нийлүүлэгчдийн тоо ----- Ирүүлсэн нь -----
6. Оролцогчид

Оролцогчдын нэрс	Харьяалал	Барааны гарлын улс /АХБ-ны гишүүн орон байх ёстой/	Үнийн санал ирүүлсэн өдөр	Үнийн саналын үнэ
1.				

7. Техникийн тодорхойлолт хангасан эсэхийг магадлах /Оролцогч тус бүрээр харьцуулах/

Оролцогч 1:

Ду.	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Оролцогчоос ирүүлсэн техникийн тодорхойлолт	Шаардлага хангасан/ эсвэл хангаагүй

Оролцогч 2:

Ду.	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Оролцогчоос ирүүлсэн техникийн тодорхойлолт	Шаардлага хангасан/ эсвэл хангаагүй

Оролцогч 3:

Ду.	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Оролцогчоос ирүүлсэн техникийн тодорхойлолт	Шаардлага хангасан/ эсвэл хангаагүй

8. Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан оролцогч

Оролцогчийн нэр	Үнийн саналын үнэ

9. Техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй оролцогч

Оролцогчийн нэр	Шалтгаан

10. Гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн оролцогчийн нэр -----
11. Гэрээний нийт үнэ -----
12. Гэрээ байгуулсан огноо -----

Огноо

*Гарын үсэг /асуудал хариуцсан ажилтан/
Гэрээнд заасан төсөл хариуцсан ажилт*

Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх
 20... оны дугаар сарын -ны өдрийн
 дугаар гэрээний 5 дугаар хавсралт

“..... ТӨСӨЛ”-ИЙН ТАЙЛАН

Төсөл хэрэгжүүлэгч баг нь төслийн хэрэгжилтийн дунд хугацааны болон эцсийн тайланг, “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл” (ХЭЭГБХТТ) хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ.

А. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ					
1.	Төслийн нэр:.....				
2.	Төсөл хэрэгжүүлэгч багийн нэр:				
3.	Төслийн санхүүжилтийн нийт дүн (төгрөгөөр): ₮.....				
4.	Тайлангийн хамрах хугацаа: 20... оны ... сарын-нээс оны сарын хүртэл				
Б. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН					
5.	Төслийн үндсэн зорилго, зорилтууд юу бэ?				
6.	Тайлангийн хугацаанд төслөөс ямар үр дүн гарсан бэ? Тухайн үр дүнд хүрэхэд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бэ? Багийн гишүүд ямар үүрэгтэй оролцсон бэ? <ul style="list-style-type: none"> • Гарсан үр дүнг төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлтээр дэлгэрэнгүй бичих • Ямар үйл ажиллагааг хэнд зориулж явуулсан, ямар өөрчлөлт бий болсон талаар бичих • Гарсан өөрчлөлтийг баримтжуулсан зураг, бичлэг хавсаргах • Багийн гишүүд ямар үүрэг хариуцлагатайгаар төслийн хэрэгжилтэд оролцсон талаар бичих 				
7.	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт гарсан уу? <ul style="list-style-type: none"> • Төлөвлөж байсан үйл ажиллагаанаас хийгдээгүй эсвэл нэмж хийх шаардлагатай үйл ажиллагаа гарсан бол ямар үйл ажиллагаа/арга хэмжээ авсан талаараа бичих 				
8.	Төслийн биелэлт хэдэн хувьтай байна вэ?				
9.	Төслөөс гарсан үр дүн цаашид хэрхэн тогтвортой байх талаар бичнэ үү?				
Б. ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН					
10.	Хүлээн авсан нийт санхүүжилт (төгрөгөөр)	Зарцуулсан нийт дүн /баримтаар нотлогдсон / (төгрөгөөр)	*Зардлын ангиллаар ¹ : (төгрөгөөр)	Үлдэгдэл (төгрөгөөр)	Тайлбар
	Үе шат 1: ₮.....	₮.....	Хэрэглээний/ зардал: ₮.....		
			Үндсэн хөрөнгийн зардал ² : ₮.....		

		Үйл ажиллагааны зардал: ₮.....		
Үе шат 2: ₮.....	₮.....	Хэрэглээний зардал: ₮.....		
		Үндсэн хөрөнгийн зардал: ₮.....		
		Үйл ажиллагааны зардал: ₮.....		
Нийт: ₮.....	₮.....		₮.....	

***Зардлын ангилал¹:**

Хэрэглээний зардал гэдэг нь Төсөл хэрэгжүүлэгч багийн унаа тээвэр, холбоо харилцаа, хоол унд гэх мэт төсөл хэрэгжүүлэх үед шаардлагатай зардлыг хэлнэ. Хэрэглээний зардал нь нийт төсвийн 10% -аас хэтрэхгүй.

***Үндсэн хөрөнгийн зардал²** гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглагдах боломжит хугацаа нь хязгаарлагдмал биет хөрөнгө болох компьютер, канон, принтер, тавилга зэрэг болно. Эдгээр үндсэн хөрөнгийг худалдан авах, угсрах, тээвэрлэхтэй холбоотой зардлыг хэлнэ. Үндсэн хөрөнгийн худалдан авалтын тайланг Хавсралт 3-т байгаа маягтаар гаргаж санхүүгийн тайланд хавсаргаж ирүүлнэ.

Үйл ажиллагааны зардал гэдэг нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг хэлнэ.

Жич: Төрийн байгууллагын албан хаагч мөнгөн хэлбэрээр урамшуулал, цалин авах эрхгүй юм. Санхүүгийн баримт бүрдүүлэлтэд холбогдох баримт материалыг тооцохгүй болохыг анхаарна уу.

ТАЙЛАН БИЧСЭН: Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүд

1. Он, сар, өдөр:.....
/овог, нэр/ /гарын үсэг/

ТАЙЛАН ХҮЛЭЭН АВСАН:

Төслийн зохицуулагч:

Асуудал хариуцсан мэргэжилтэн:

.....
/овог, нэр/

.....
/овог, нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

Санхүүгийн тайланг хянасан:

Тайлантай танилцсан:

.....
/овог, нэр/

.....
/овог, нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/